



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 27 өдөр

Дугаар A/349

Булган сум

Гамшгийг тэсвэрлэх чадавхын үнэлгээг хийж,  
Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг  
шинэчлэн боловсруулах ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь” санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд “Гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх аргачлалын дагуу” үнэлэх, Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Гамшгийг тэсвэрлэх чадавхын үнэлгээг хийж Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах ажлыг 2025 оны 05 дугаар сарын 27-28-ны өдөр зохион байгуулсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наанбаяр), Онцгой байдлын газрын дарга, (Дэд хурандаа Н.Хишигдорж) нарт тус тус үүрэг болгосугай.



Аймгийн Засаг даргын 20.05 оны  
05 дугаар сарын 27-ны/ний өдрийн  
A/349 дугаар захирамжийн хавсралт

**"ХОТУУДЫН ГАМШГИЙГ ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ ОНООНЫ АРГААР ҮНЭЛЭХ"  
АРГАЧЛАЛЫН ДАГУУ ҮНЭЛГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга)
- Гишүүд:  
М.Цэрэнчимэд (Аймгийн Ерөнхий архитектур)  
Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын  
хэлтсийн дарга)  
Н.Очирхуяг (Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын Барилга, техникийн хяналтын  
улсын байцаагч)  
А.Оюунболд (Цагдаагийн газрын Нийтийн хэв журам  
хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах  
тасгийн дарга, Хошууч)  
Г.Дуламсүрэн (Нийгмийн даатгалын газрын Захиргаа,  
хяналтын хэлтсийн дарга)  
Б.Алтанбулаг (Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн  
хяналтын улсын байцаагч)  
Г.Баяржаргал (Байгаль орчны газрын Биологийн төрөл  
зүйл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ,  
тусгай хамгаалалттай газар нутаг, судалгаа шинжилгээ  
хариуцсан мэргэжилтэн)  
Ч.Шүрэнцэцэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
С.Ариунаа (Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний  
тандалт хариуцсан мэргэжилтэн)  
Б.Авиurmэд (Автотээврийн Үндэсний төвийн Булган  
салбарын Автотээврийн улсын байцаагч)  
Б.Баяржаргал ("Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК-ийн  
Булган аймгийн Газрын дамжуулах байгууламжийн  
инженер)  
Г.Лхагважаргал ("Эрдэнэт-Булган цахилгаан түгээх  
сүлжээ" Төрийн өмчит хувьцаат компанийн Булган  
аймаг дахь салбарын Ахлах инженер)  
М.Мөнх-Эрдэм ("Булган АЗА" ТӨХК-ийн Булган аймаг  
дахь салбарын Ерөнхий инженер)  
Э.Нямсүрэн ("Булган-Мээж" ХХК-ийн Ерөнхий инженер)  
Х.Чинзориг (Онцгой байдлын газрын Гал түймрийн  
улсын хяналтын ахлах байцаагч, Хошууч)

Ж.Лхагважаргал (Онцгой байдлын газрын Эрэн хайх,  
аврах салбарын захирагч, Дэд хурандаа)  
Э.Мөнх-Эрдэнэ (Онцгой байдлын газрын Ангиллын  
сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал  
хариуцсан мэргэжилтэн, Дэслэгч)  
Б.Чулунцэцэг (Онцгой байдлын газрын Гамшигийн  
эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан  
мэргэжилтэн, Дэслэгч)  
3.Батбагана (Булган сумын Засаг даргын Тамгын  
газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
Б.Нямсүрэн (Булган сумын Засаг даргын Тамгын  
газрын Нийгмийн салбар хариуцсан мэргэжилтэн)  
Нарийн бичгийн дарга: Ж.Болдбаатар (Онцгой байдлын газрын Гамшгаас  
хамгаалах төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдал хариуцсан  
ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа)